

**МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ**  
**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН ТАЙЛАН**  
**/Жилийн эцэс/**

2023 оны 12 дугаар сарын 04-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>6. ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ</b>							
						<b>"Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"</b>	
20	9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ.	9.5.4. Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025			<ul style="list-style-type: none"> <li>НБМҮТП-ийн үндсэн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтад 2023 онд нийслэлийн төсвөөс 500,000,000 төгрөг тусгагдсан бөгөөд төсвийн тодотголоор 7,500,000,000 төгрөг тусгагдсан. Мөн үлдэгдэл санхүүжилт болох 6,208,000,000 төгрөгийг Нийслэлийн 2024 оны төсөвт батлуулсан.</li> <li>1000 м3 цэвэрлэх байгууламжийн Барилга, Хот байгуулалтын яамнаас 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулахаар баримт бичгийг бэлтгэн хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй болно. Иймд 2024 оны улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар баримт бичгийг бэлтгэн хүргүүлсэн болно. Мөн уг ажлын хүрээнд 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 1000 м3 цэвэрлэх байгууламжийн ажлын шинэчилсэн төсвийг "ББСМО" ХХК-р батлуулан авсан. Нийт төсөвт өртөг 5,325,917,742 төгрөг.</li> <li>26 МВт-ийн дулааны станцын хөрөнгө оруулалтыг Эрчим хүчний яамнаас 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулахаар баримт бичгийг бэлтгэн хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. Иймд 2024 оны улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар баримт бичгийг бэлтгэн хүргүүлсэн болно. Нийт төсөвт өртөг 14,335,049,000 төгрөг.</li> <li>ҮТП-ийн дэд бүтцийн ажлуудын гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслүүдийн хөрөнгө оруулалтыг</li> </ul>	50

					<p>шийдвэрлүүлэхээр НЗДТГ, БХБЯ болон холбогдох газруудад хүсэлт гаргасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Парк нь өөрийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоогийн байдлаар 250 га газарт нийт 52 аж ахуй нэгжтэй үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар 24 аж ахуйн нэгжтэй гэрээ дүгнэн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, бичиг баримт, зураг төслийн бүрдлийг хангах шаардлага хүргүүлсэн бөгөөд 9 аж ахуй нэгжтэй гэрээ цуцалсан. 10 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулах газарт хашаа барин үйлдвэрийн барилга байгууламжаа барих бэлтгэл ажлыг хангаад байна. 5 аж ахуй нэгж бичиг баримтын бүрдэл хангагдан үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн бөгөөд барилга угсралтын ажил 80%-тай явагдаж байна. 5 аж ахуйн нэгжид үйлдвэрийн бүтээн байгуулалтад шаардлагатай цахилгаан хангамжийн түр тэжээлээр хангаад байна.</li> <li>• “Таван толгой түлш” ХХК –ийн усан хангамжийн ажил гол болон салбар шугамын шуудууны буцаан булалтыг механизмаар тэгшлэх, усан сан насос станцын барилгын гадна цахилгаан, автоматжуулалтын ажил, үзлэгийн худгууд дотор хаалт арматурын бетон зутгах, ус дамжуулах салбар шугамын даралт шалгах тестийн ажил, гүний худгууд насос станцын автоматжуулалтын ажил зэрэг ажлууд хийгдэж дууссан. 2023 оны 09 дүгээр сарын 28 ны өдөр “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн үйлдвэрийн ус хангамжийн барилга угсралтын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөх техникийн улсын комисс ажиллав.2 худгийн барилгын ажил хийгдэж байна. “ТТТ” ХХК-руу татах 6.3 км шугам хоолойн газар шорооны ажил хийгдэж байна.</li> <li>• Барилга хот байгуулалтын сайдын 2020.09.07-ны өдрийн 169 дугаар тушаалын дагуу паркийн өргөтөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явагдаж 228.8 сая төгрөгөөр “Өрх” ХХК 2021.01.28-ны өдөр 2021/47 дугаар гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл дууссан ба</li> </ul>
--	--	--	--	--	---

					мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт болон магадлал хийлгэх ажлууд хийгдэж байна.	
--	--	--	--	--	---	--

ЗӨВШӨӨРСӨН:  
НБМҮТП ОНӨТҮГ-ЫН ДАРГА

ХЯНАСАН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.БАТЖАРГАЛ

Н.ПҮРЭВСҮРЭН

Х.БЯМБАА